

РЕЗИДЕНТ ЭМЧИЙН СУРАЛЦАН АЖИЛЛАХ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

Дугаар: рti12.....

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Хөдөлмөрийн гэрээг /цаашид “гэрээ” гэх/ нэг талаас Анагаахын Шинэлэх Ухааны Үндэсний Их Сургууль /Сургалт эрхлэх байгууллага/-ыг төлөөлж Мэргэжил Дээшлүүлэх Институтийн захирал Түмэнбаяр овогтой Баясгалан (цаашид “ажил олгогч” гэх) нөгөө талаас резидент эмчрегистрийн дугаартай.....овогтой..... (цаашид “резидент эмч” гэх) нар Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг баримтлан дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээний гол нөхцөл:

1.3.1. Ажлын байрны буюу албан тушаалын нэр: резидент эмч

1.3.2. Харьяалагдах нэгжийн нэр: Мэргэжил Дээшлүүлэх Институт

1.3.3. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг: АШУҮИС-ийн эмнэлэг, эмнэлгийн тасаг, нэгж, бусад

1.3.4. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ: ТҮЭМ-4 (резидент эмч) ангиллаар

1.3.5. Хөдөлмөрийн нөхцөл: хэвийн/ хэвийн бус (доогуур зурна уу)

1.3.6. **Хөдөлмөрийн гэрээний хугацаа:** _____ /Суралцан ажиллах хугацаагаар байгуулна./

1.3. Ажил амралтын цаг:

1.3.1. Өдрийн ажлын цаг нь 8 цаг байна. Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна.

1.3.2. Ажлын цагийг резидент эмч зөвхөн үүрэгт ажлаа бүрэн биелүүлэхэд зориулж, өөрийн бүх мэдлэг чадвар, хандлага, мэргэжил, анхаарлаа дайчлан суралцаж, дадлага эзэмшин ажиллана.

1.3.3. Ажлын зайлшгүй шаардлага, захиргааны шийдвэрээр резидент эмчийг илүү цагаар ажиллуулж болно. Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол хөдөлмөрийн тухай хуулийн 109.1, 109.2, 109.3, 109.4, 109.5, 109.6-д заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг шийдвэр гаргасан байгууллага нэмж олгоно.

1.3.4. Нийтлэг эрх ашгийн үүднээс эрхэлж буй ажлаас өөр чиглэлийн ажилд ажлын болон ажлын бус цагаар түр хугацаагаар татан оруулах асуудлыг хоёр тал тохиролцон гүйцэтгэх ба энэхүү гэрээний 1.3.3-д заасан илүү цагаар ажилласан бол нөхөн амарч болно.

1.3.5. Ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар суралцах хугацаанд ажлын 15 өдөр хүртэл (ажилласан хугацаагаар тооцох) олгоно. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь заалтыг үндэслэн олгож болно.

1.4. Сургалтын чиглэл, хугацаа, төлбөр

1.4.1. **Сургалт явуулах мэргэжлийн чиглэл:**

1.4.2. Сургалтын төрөл: үндсэн мэргэшил

1.4.3. Сургалтын төлбөрийн хэлбэр: төрийн санхүүжилт, байгууллага, хувийн зардал (доогуур зурна уу)

Хоёр. Талуудын эрх, үүрэг

Хөдөлмөрийн гэрээ байгуулагч талууд нь МУ-ын хууль тогтоомжид заасны дагуу харилцан эрх эдэлж үүрэг биелүүлэн, хариуцлага хүлээнэ.

2.1. Ажил олгогч дараах эрх эдэлнэ:

2.1.1. Мэргэжил Дээшлүүлэх Институт нь хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулан баталж, мөрдүүлэх;

2.1.2. Тухайн тойролт хийж буй эмнэлэг нь хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм, журмыг резидент эмчид танилцуулж, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг резидент эмчээс шаардах;

2.1.3. Эрхэлсэн ажил үүргээ хугацаанд нь тогтсон дүрэм, журам, стандарт, холбогдох тушаал, шийдвэрийн дагуу чанартай гүйцэтгэж тайлагнахыг шаардах;

2.1.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, санал, санаачлаг, идэвх зүтгэлийг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэх, урамшуулах;

2.1.5. Сахилгын хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдсэн тохиолдолд Хөдөлмөрийн хууль, дотоод журам, гэрээнд зааснаар сахилгын шийтгэл ногдуулах;

2.1.6. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллуулах;

2.1.7. Урьдчилан мэдэх боломжгүй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь гэрээнд заагаагүй өөр ажилд түр хугацаагаар шилжүүлэх;

2.1.8. Гэрээ цуцлагдах нөхцөл байдал бий болсон үед резидент эмч ажлаа зохих ёсоор хүлээлцээгүй бол цалин хөлсийг олгохгүй байх;

2.1.9. Резидент эмчийн шалгуур үзүүлэлтэд сар бүр хяналт тавьж, гарын үсгээр баталгаажуулах; (Резидент эмчийн шалгуур үзүүлэлтийг энэхүү гэрээнд хавсаргав)

2.1.10. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ оношилгооны стандарт, заавар, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг резидент эмчээс шаардах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох;

2.1.11. Хуулиар олгогдсон бусад эрх.

2.2. Ажил олгогч дараах үүргийг хүлээнэ:

2.2.1. Энэхүү гэрээгээр тохиролцсон ажлын байраар хангах, ажиллан суралцах нөхцөл бүрдүүлэх, эмнэл зүйн сургагч багшийг томилох, тасаг, нэгжид хуваарилах;

2.2.2. Холбогдох дээд байгууллагаас санхүүжилт орсон тохиолдолд Хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалинг гэрээнд заагдсан хугацаанд тогтмол олгох;

2.2.3. Ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай ажлын байрны тоног төхөөрөмж, ширээ сандал, бичгийн хэрэгсэл, мэдээ, мэдээлэл зэрэг бусад нөхцөлөөр хангах;

2.2.4. Резидент эмчийн үйлчлүүлэгчид бие даан үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг Мэргэжлийн салбар зөвлөлөөс баталсан жагсаалт, үндсэн мэргэшлийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй нийцүүлэн тухайн суралцагчийн дэвтрээр хангах батлах;

2.2.5. Резидент эмчид Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд зааснаар туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

2.2.6. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

2.2.7. Резидент эмчээс гаргасан шинэ санал, санаачилга, бүтээлч байдлыг дэмжиж ажиллах;

2.2.8. Резидент эмчийг хамгаалах хувцас хэрэгсэл, гарын авлага, хөтөлбөр, суралцагчийн дэвтрээр хангах;

2.2.9. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д заасны дагуу резидент эмчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулах, мөн хуулийн 20.2.7-д заасны дагуу эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.2.10. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ оношилгооны удирдамж, стандарт, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг резидент эмчээс шаардах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох;

2.2.11. Резидент эмчийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, судалж шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, үндсэн байгууллагаас дэмжсэн тохиолдолд суралцуулах боломжоор хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2.2.12. Суралцагчдад сургалтын хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар ажлын 1 хоногийн чөлөөг зохицуулагч багш, ажлын 2-5 хүртэлх хоногийн чөлөөг суралцагчийн өргөдлийг үндэслэн зохицуулагч багшийн саналаар Мэргэжил Дээшлүүлэх Институт олгож захиалгаар суралцуулж буй байгууллагад мэдэгдэх;

2.2.13. Хуульд заасан бусад үүрэг.

2.3. Резидент эмч нь дараах эрх эдэлнэ:

2.3.1. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ үгээр, биеэр, цахимаар болон хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах, ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэсэн тохиолдолд Мэргэжил Дээшлүүлэх Институтэд хандаж шийдвэрлүүлэх;

2.3.2. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах;

2.3.3. Гэрээгээр тохиролцсон цалин авах, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэмж авах;

2.3.4. Хөдөлмөрийн хууль, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын хөдөлмөрийн дотоод болон бусад дүрэм, журам, гэрээнд зааснаар ажиллах, амрах, туслалцаа дэмжлэг авах;

2.3.5. Өөрийн ажлын үр дүнг үнэлүүлэх улмаар төр засаг, салбар, байгууллагын шагналд нэрээ дэвшүүлэх, урамшуулал авах;

2.3.6. Эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

2.3.7. Сургалт эрхлэх байгууллагатай үндсэн мэргэшлийн сургалтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулах, суралцах орчин нөхцөл, хамгаалах хувцас хэрэглэлээр хангуулах;

2.3.8. Үндсэн мэргэшлийн сургалтад суралцан ажиллах хугацаанд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон дархлаажуулалтад төлбөргүй хамрагдах;

2.3.9. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, хүсэлт, гомдлыг гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах;

2.3.10. Хууль, дүрэм, журам, стандарт нь хэрэгжих боломжгүй, үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэхгүй байгаа тохиолдолд түүнийг өөрчлүүлэх тухай саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу ажил олгогчид тавих;

2.3.11. Сургалтын хугацаанд хоёр удаа өөрийн хүсэлтээр нэг жилийн чөлөө авах;

2.3.12. Ээлжийн амралтыг суралцах хугацаандаа хуваарийн дагуу нэг удаа ажлын 15 өдөр биеэр эдлэх.

2.3.13. Сургалтын хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар холбогдох баримт бичгийг хавсарган өргөдлийг Мэргэжил Дээшлүүлэх Институт ирүүлж гэрээнд заасны дагуу чөлөө авах;

2.3.14. Сургалтыг амжилттай төгссөн, төлбөр, тооцоог бүрэн хийсэн тохиолдолд мэргэшлийн үнэмлэх авах;

2.4 Резидент эмч дор дурдсан үүрэг хүлээнэ:

2.4.1. Гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэхдээ мэдлэг чадвараа дайчлан үнэнч шударгаар ажиллан, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, хамт олны дунд ажил хэрэгч, нөхөрсөг эвсэг харилцааг эрхэмлэх;

2.4.2. Мэргэжил Дээшлүүлэх Институтийн захирлын баталсан хуваарийн дагуу томилогдсон эмнэл зүйн сургагч багшаар удирдуулан, хуваарилагдсан тасаг, нэгжид ажиллах;

2.4.3. Ажил олгогчоос баталж мөрдүүлж буй Хөдөлмөрийн дотоод болон бусад дүрэм, журам, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэж чанд мөрдөж ажиллах;

2.4.4. Эрүүл мэндийн тухай хууль, Халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллах;

2.4.5. Мэргэжил Дээшлүүлэх Институтээс зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, илтгэл мэдээлэл хэлэлцүүлэх, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх;

2.4.6. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллах;

2.4.7. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүний эрхийг хангах, гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.4.8. Сонор сэрэмжтэй байж, ажлын байрны аюулгүй ажиллагаанд анхааран, хөдөлмөр хамгааллын шаардлагыг дагаж ажиллах, хариуцаж буй тоног төхөөрөмж, машин техник, хэрэгслийн дүрэм зааврыг чанд мөрдөх, болзошгүй аюулаас сэргийлэх;

2.4.9. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд онц аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож энэ тухайгаа эмнэлзүйн сургагч багшид мэдэгдэх;

2.4.10. Байнга хийгддэг олон дахин давтагддаг үйлдлүүдэд (ажилд) эрсдэлтэй ажил, хэвийн бус болон яаралтай, онцгой нөхцөл, тохиолдолд ажиллах зааварчилгаа, хяналтын хуудсыг ажилдаа нэвтрүүлж, аливаа эрсдэл, алдаа гарахаас өөрийгөө болон хамт олноо сэргийлж ажиллах;

2.4.11. Бүртгэлээр хариуцуулсан үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хайрлан хамгаалж, тэдгээрийг үр ашигтай зарцуулах, өөрийн буруугаас эвдэж гэмтээсэн, алдаж үрэгдүүлсэн бол байгууллагаас тогтоосон үнийн дүнгээр төлж, хохиролгүй болгох;

2.4.12. Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах;

2.4.13. Ажил, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

2.4.14. Сургалтаас гарах тухай хүсэлтийг нэг сараас доошгүй хугацааны өмнө ажил олгогчид бичгээр өргөдөл гарган албан ёсоор мэдэгдэх;

2.4.15. Энэхүү гэрээнд зааснаас гадна ажил олгогчоос өгсөн хуульд нийцсэн бусад шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх;

2.4.16. Ажилдаа ирэх болон тарах цагийг цаг бүртгэлийн програмд болон бусад бүртгэлийн дэвтэрт бүртгүүлэх ба энэ нь ажилтанд цалин олгох үндэслэл болох.

2.4.17. Тасралтгүй ажиллагаатай тасагт ээлжид ажиллаж буй тохиолдолд ажилтан дараагийн ээлжийн ажилтан ирээгүй байхад дур мэдэн ажлаа орхиж явахыг хориглох. Хүлээлгэсэн цагийн мөнгийг буруутай этгээдийн цалин хөлснөөс суутган, шилжүүлэн олгох.

2.4.18. “Цахим өвчний түүх” программд нэвтрэх эрхтэй резидент эмч нь зөвхөн өөрийн кодоор нэвтэрч, зохих журмын дагуу ажиллах ба өвчтөний хувийн нууцтай холбогдох мэдээллийг задруулахгүй байх;

2.4.19. Суралцан ажиллах хугацаанд сургалтад бүрэн хамрагдаж энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд сөргөөр нөлөөлөх, эрсдэл бий болгох бусад ажил, хөдөлмөр эрхлэхгүй байх, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргээ гүйцэтгэх, суралцах хугацааны ажлын гүйцэтгэл, ажлын цаг, ажил үүрэгт зохицуулалт хийсэн тохиолдолд энэ заалт хамаарахгүй байж болно;

2.4.20. Батлагдсан хуваарийн дагуу жижүүр эмчийн үүрэг гүйцэтгэх;

2.4.21. Сургалтын төлбөрийг тухайн жилийн эхний 2 сард багтаан бүрэн төлж барагдуулах;

2.4.22. Суралцан ажиллах хугацаанд эмчлэх эрхийн лицензийн хугацаа дуусахаар бол зохих хугацаанд нь сунгуулан Мэргэжил Дээшлүүлэх Институтэд хүргүүлэх;

2.4.23. Сургалтын төлбөр, зардлын бодит тооцоо төрийн санхүүжилтээр төлж байгаа санхүүжилтээс хэтэрсэн тохиолдолд төлбөр, тооцооны үндэслэлийг танилцсаны үндсэн дээр төлбөрийн зөрүүг резидент эмч өөрөө хариуцах.

2.4.24. Резидент эмчийн шалгуур үзүүлэлтийг сар бүр бөглөж Зохицуулагч багшийн гарын үсгээр баталгаажуулан Мэргэжил Дээшлүүлэх Институтэд хүргүүлэх (Резидент эмчийн шалгуур үзүүлэлтийг энэхүү гэрээнд хавсаргав)

2.4.25. Сургалтаас чөлөө авсан эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулан сурч байгаа тохиолдолд сургалтын хугацаа дуустал дахин резиденсийн сургалтад шинээр элсэхгүй байх;

2.4.26. Сургалтын хугацааг дуусгаагүй тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр резидент эмчийн санаачлагчаар хөдөлмөрийн гэрээ цуцалсан тохиолдолд суралцсан хугацааны цалинг буцаан төлөх;

Гурав. Сургалтын төлбөр, түүнийг төлөх

3.1. Сургалтын төлбөрийн жишиг үнийг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалыг үндэслэн тогтооно.

3.2. Резидент эмч сургалтын төлбөртөгрөгийг АШУҮИС-ийн **5031882309** ХААН БАНК-ны тоот дансанд тухайн хичээлийн жилийн эхний 2 сард багтаан төлнө.

Дөрөв. Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага

4.1. Хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, байгууллагын баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн резидент эмчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасанчлан дор дурдсан хэлбэрийн сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

4.1.1. “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах;

- Ажлын цагийг үр ашиггүй өнгөрүүлэх, ажлын цагаар сэлгүүцэх;

- Хүндэтгэх шалтгаангүйгээр ажлын нэг сарын хугацаанд ажлаас хоцорсон (нийлбэр нь нэг өдөр), эсвэл нэг өдрийн ажил таслах;

- Үйлчлүүлэгч болон нас барагчийн ар гэрээс ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдол үндэслэлтэй нь нотлогдсон;

4.1.2. “үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлд:

- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоёр өдрийн ажил таслах;

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй үнэлгээ авсан бол;

- Төлөвлөгөөт болон цаг үеийн үзлэг, шалгалт болон хөндлөнгийн хяналт шалгалтаар хариуцан ажиллаж буй албаны үйл ажиллагаа нь хангалтгүй үнэлэгдэх;

- Албан үүргээ хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй биелүүлсэн бол

- Резидент эмчийн шалгуур үзүүлэлтийн 80 хувьд хүрээгүй тохиолдолд үндсэн цалингийн 10 хувийг хасах

4.1.3. “Сургалтаас хасах буюу ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах сахилгын шийтгэлд:

- Эмчилгээ, оношилгоо, эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, стандарт, зааврыг ноцтой зөрчих;

- Мэргэжлийн алдаа гаргаж, хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон;

- Ажлын байранд (албан үүргээ гүйцэтгэж байгаа бүх нөхцөл) согтууруулах ундаа, согтуурсан, мансууруулах бодис хэрэглэх, шалгуулахаас зайлсхийсэн, зугтаасан бол;

- Байгууллагын болон хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой нууцыг задруулах, түгээх;

- Байгууллагын эд хөрөнгийг дур мэдэн авч гарах, завдах, завших, ашиг олгох зорилгоор хэрэглэх;

- Байгууллагын нэр хүндийг гутаах, санаатайгаар унагах зэргээр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үндэслэлгүйгээр түгээх;

- Сахилгын зөрчлийг давтан гаргасан;

- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/226 дугаар тушаалаар баталсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам”-ыг зөрчсөн бол.

- АШУҮИС-ийн захирлын 2023 оны А/15 дугаар тушаалаар баталсан “төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-г зөрчсөн бол.

- Бусад дүрэм, журам, гэрээ, тодорхойлолт, эрх зүйн актад заасныг зөрчсөн бол

4.2. Резидент эмч ёс зүйн алдаа гаргасан нь батлагдсан, сурлагын дэвтэрт хуурамч тэмдэглэгээ хийсэн, тойролтыг хуваарийн дагуу хийгээгүй, байгууллагын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан, мэргэжлийн алдаа гаргасан бол энэхүү гэрээг цуцална.

Тав. Гэрээг өөрчлөх, дуусгавар болгох

5.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 50, 51-53, 56-59, дүгээр зүйлд заасан үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар энэхүү гэрээг түр өөрчилж болно.

5.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 78, 79, 80 дугаар зүйлүүдэд заасан үндэслэлээр энэхүү гэрээг дуусгавар болгоно.

5.3. Гэрээ байгуулагч хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээнд тусгагдаагүй асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актаар зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧ:

Мэргэжил Дээшлүүлэх Институт
захирлын нэр: Т.Баясгалан
Утас: 77757575 – 1027
Хаяг: АШУҮИС, С.Зоригийн гудамж,
Улаанбаатар 14120, Монгол Улс

РЕЗИДЕНТ ЭМЧ:

Ургийн овог:
Эцэг/эхийн нэр:
Резидент эмчийн нэр:
Утас:
Хаяг:

Гарын үсэг: _____

ТЭМДЭГ

.....оны.....сарын-ны өдөр

Гарын үсэг: _____

ТЭМДЭГ

.....оны.....сарын-ны өдөр